



**Тогтвортой
ноос ноолуурын
ЭВСЭЛ**

*Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой
байдлыг хөгжүүлэхийн төлөө*

БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧ МАЛЧДЫН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ



БИДНИЙ ТУХАЙ

Тогтвортой Ноос Ноолуурын Эвсэл (ТННЭ) нь Их Британи улсад бүртгэлтэй олон улсын гишүүнчлэлтэй, ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг байгууллага.

Бид ноолуурын нийлүүлэлт ба үйлдвэрлэлийн салбарт эерэг нөлөөллийг бий болгох, тогтвортой байдлын зарчимд нийцүүлэн хөгжүүлэхэд чиглэгдсэн "ТННЭ-ийн Ноолуурын Стандарт"-ыг Олон улсын нийгэм-байгаль орчны итгэмжлэл ба тэмдэгтийн байгууллага (ISEAL)-ын цогц дүрмийн дагуу тогтоох, тасралтгүй хөгжүүлэх чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Бидний алсын хараа Байгаль орчинд ээлтэй, мал амьтдын тав тухтай амьдрах орчныг хангасан, малчдын баталгаат амьжиргааг дэмжсэн ноолуурын үйлдвэрлэлийг бий болгох



Бидний эрхэм зорилго ТННЭ-ийн Ноолуурын Стандартыг нэвтрүүлж, хариуцлагатай ажиллагааны дадлуудыг үе шат бүрт хэвшүүлснээр ноолуурын үйлдвэрлэлийн салбарыг шинэ түвшинд хүргэх

Бидний үндсэн 3 зорилго:

1. Байгаль орчинд ээлтэй ноолуурын үйлдвэрлэл эрхлэх
2. Малчдын амьжиргааг дэмжих
3. Бэлчээр болон зэрлэг амьтдын нөөц баялгийг хамгаалах

ТННЭ нь сайн засаглалын зарчим, хамтын зөвшилцлийн дүрмээр дэлхийн ноолуурын зах зээлийн 80 орчим хувийг эзэлдэг 100 гаруй тэргүүлэгч бренд, үйлдвэр, худалдаа эрхлэгчдийг нэгтгэсэн эвсэл юм. Нийгэм болон байгаль орчны хариуцлагаа дээшлүүлэх, тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих, бидний алсын хараа, эрхэм зорилгод нийцэх зорилго нэгт байгууллагуудад манай гишүүнчлэл нээлттэй байдаг.

Гишүүн байгууллагууд:



Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдлыг хөгжүүлэхийн төлөө

ЭВСЭЛД НЭГДЭХИЙН ДАВУУ ТАЛ

Олон улсын зах зээл дээр хүн-байгальд халгүй, мал амьтанд ээлтэй байдлын шалгуураар баталгаажсан түүхий эдийн эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгаатай холбоотой ТННЭ-ийн баталгаажуулалт нь малчны байгууллагад олон давуу талыг бий болгож байна. Үүнд:



Түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх

ТННЭ нь Малчин-Хоршоо-Үйлдвэр хоорондын эргэх холбоог сайжруулж итгэлцлийн түвшин, урт хугацааны худалдааны түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлэх, малчдын зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн төлөө ноолуурын гарал үүсэл ба чанарын хяналт, мөшгөлтийн тогтолцоог хөгжүүлэн ажиллаж байна.



Түүхий эдийн бэлтгэлийн чанараар зах зээлд давуу байдлаар өрсөлдөх

Хоршоод нь илүү олон малчин өрхийг нэгтгэж, түүхий эдийн бэлтгэлийн чанараа сайжруулснаар үнэ цэнийг нэмэгдүүлэх боломжтой. Чанарын шаардлага хангасан, тодорхой стандартад нийцсэн түүхий эд бэлтгэхэд хөшүүрэг болох "Ноолуур ангилан бэлтгэх" чадамжид суурилсан сургалтанд хамрагдсан малчны байгууллага нь сургалтанд хамрагдаагүй малчны байгууллагатай харьцуулбал ноолуураа илүү өндөр үнээр борлуулдаг.



Мэдлэг дамжуулах, сайн туршлага солилцох уулзалт, сургалт

ТННЭ нь Малчны байгууллагуудад олон улсын зах зээлийн шаардлага шалгууртай танилцаж, худалдааны харилцаагаа бэхжүүлэх боломжуудыг олгодог. Бид малчны байгууллагуудад зориулан мал аж ахуй эрхлэх, ноолуур бэлтгэх зохистой дадал болон бэлчээр ашиглах зохистой дадлын сургалтуудыг тогтмол ордог. Мөн чадамжид суурилсан сургалт, гишүүн малчны байгууллагуудын удирдлагын сар бүрийн уулзалт, хоршоо ба үйлдвэрийн түншлэх уулзалт, ТННЭ-ийн ээлжит олон улсын хурал зэрэг олон төрлийн арга хэмжээ зохион байгуулдаг.



Чанарын үнэлэмж бүхий нэмүү өртгийн сүлжээнд малчдын оролцоог нэмэгдүүлэх

Малчдыг бэлтгэн нийлүүлэгчийн үүргээ ухамсарлан түүхий эдийн хариуцлагатай бэлтгэн нийлүүлэлт, зах зээлийн стандартын шаардлага, бүтээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх талаар ойлголттой болж өөрсдийн амьжиргаа, орлогыг нэмэгдүүлэхийг дэмждэг.




Хөнгөлттэй зээлээр дамжуулан санхүүгийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх

Баталгаажсан малчдын байгууллагуудын зээлийн эргэн төлөлтийн ачааллыг бууруулах, санхүүгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор ХААН Банктай хамтран "Тогтвортой ноос, ноолуур бэлтгэх ногоон зээл"-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллаж байна. Малчдын байгууллагуудыг энэхүү зээлийн хөтөлбөрт хамрагдахад Банкны зүгээс тавих шаардлага, урьдчилсан нөхцөлийг хангахад ТННЭ дэмжлэг үзүүлдэг.

ТННЭ-ИЙН МАЛЧДЫН БАЙГУУЛЛАГЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

2015 онд бид ноолуурын тогтвортой байдлын дэлхийн анхны цогц стандарт болох “ТННЭ-ийн Ноолуурын Стандарт”-ыг боловсруулсан.

Стандартын гол цөм нь үйлдвэрлэгчид (малчид, хоршоод, боловсруулагчид) ТННЭ-ийн баталгаажилттай болохын тулд дагаж мөрдөх шалгуур, шаардлагуудыг тодорхойлсон манай зохистой дадлын дүрэм юм. Бид сургалт, чадавхийг бэхжүүлэх замаар үйлдвэрлэгчдэд өөрсдийн үйл ажиллагаандаа зохистой дадлыг¹ нэвтрүүлэхэд нь тусалдаг бөгөөд баталгаажуулалтын үйл явц нь үе шаттай (гурван талт) явагдаж, бие даасан хөндлөнгийн байгууллагын үнэлгээг хамардаг.



2022 оны эхний улирлын байдлаар 60 гаруй малчны байгууллага зохистой дадлыг өөрсдийн үйл ажиллагаанд нэвтрүүлж ТННЭ-ийн Баталгаажилттай болоод байна. Зохистой дадлыг нэвтрүүлснээр зах зээл, хэрэглэгчдэд чанартай түүхий эд бэлтгэн нийлүүлэгч гэдгээ батлан харуулж байна гэсэн үг юм.

“МАЛ АЖ АХУЙ ЭРХЛЭХ, НОЛУУР БЭЛТГЭХ ЗОХИСТОЙ ДАДАЛ”



Олон улсын түвшинд баримталдаг мал, амьтныг хамгаалах таван эрх чөлөөний зарчмыг тусгасан. Зохистой дадлын шалгуур үзүүлэлтүүдэд тэжээл ба усан хангамж, мал маллах орчин, арчилгаа маллагаа, малын эрүүл мэнд, ямаагаа самнах, ноолуур бэлтгэх, тээвэрлэхтэй холбоотой шаардлагууд төдийгүй эрсдэлийг бууруулах зэрэг 70 гаруй үзүүлэлтүүд багтсан.



“БЭЛЧЭЭР АШИГЛАХ ЗОХИСТОЙ ДАДАЛ”



Бэлчээр ба байгалийн нөөц, зэрлэг амьтдыг хамгаалахын тулд малчдын зүгээс үүрэг хариуцлага, хамтын ажиллагааг хэрхэн хангах талаар тусгасан 30 гаруй үзүүлэлтийг багтаасан. Үүгээр малчдын бэлчээр ба байгалийн нөөцөө зохистой ашиглаж буй сайн туршлагыг хөхүүлэн дэмжиж, нутаг дэвсгэр, уур амьсгалынхаа орчин нөхцөлд зохицсон арга туршлагыг нэвтрүүлж буйг үнэлж, баталгаажуулах боломжийг бүрдүүлж байна.



Малчдын байгууллага нь “Мал аж ахуй эрхлэх, ноолуур бэлтгэх” болон “Бэлчээр ашиглах зохистой дадал”-ын шалгуурт нийцсэн тохиолдолд ноолуураа “ТННЭ-ийн баталгаажсан” хэмээн борлуулах эрхтэй болно².



¹ Мал аж ахуй эрхлэх, ноолуур бэлтгэх зохистой дадал болон Бэлчээр ашиглах зохистой дадлын сургалтыг бүртгэлтэй малчид, хоршоод зайлшгүй хүлээн авна.

² ТННЭ-ийн баталгаажсан ноолуур, ТННЭ-ийн мөшгөх тогтолцооны талаарх мэдээллийг “Мөшгөлтийн тогтолцооны тухай” гарын авлагаас уншина уу.

ТННЭ-Д ХЭРХЭН НЭГДЭХ ВЭ?

ТННЭ-д нэгдэж, баталгаажсан нийлүүлэгч малчны байгууллага болохыг хүсвэл:

1

ТННЭ-ийн тухай мэдээлэл авч, элсэх шийдвэр гаргах

Өөрсдийн хүсэл санаачлаагаар, гишүүдийн сонирхолд тулгуурласан байх шаардлагатай.

2

ТННЭ-д бүртгүүлэх

- 2.1 Малчны байгууллагын маягт бөглөх
- 2.2 Бүртгэлийн дугаар авах

3

Сургалтанд хамрагдах

ТННЭ-ийн баталгаажуулалтын шаардлагыг хангахад шаардлагатай

- 3.1 ТННЭ-ийн МАА-н зохистой дадал ба Бэлчээр ашиглах зохистой дадлын тухай танилцуулга, шаардлага, хэрэгжилтийг хангах тухай сургалт
- 3.2 Чадвар, чадамжийг бэхжүүлэх сургалт, арга хэмжээнд хамрагдана.

4

“ТННЭ-ийн Ноолуурын Стандарт”-ын дагуу баталгаажуулалтанд хамрагдах

Тохирлын үнэлгээ явуулах дараалал

- 4.1 Баталгаажуулалтанд хамрагдах хүсэлт
- 4.2 Өөрийн дотоод үнэлгээг явуулж тайлангаа илгээх
- 4.3 Өөрийн үнэлгээнд ТННЭ-ийн хороо дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргана
Зөвлөмж болон тайлбарыг өгч зохистой дадлын тохирлыг нэмэгдүүлэх
- 4.4 Хөндлөнгийн тохирлын үнэлгээнд хамрагдах
Баталгаажуулалтын байгууллага (бие даасан хөндлөнгийн этгээд) – **БНМБ-ууд жил бүр хамрагдана**

5

ТННЭ –ийн баталгаажуулалтын гэрчилгээ авах (алт эсвэл мөнгө, хүрэл)

Малчны байгууллагын бэлтгэсэн ноолуур нь ТННЭ-ээр баталгаажна.

6

Мөшгөлттэй ТННЭ-ийн баталгаажсан ноолуурын ханган нийлүүлэлтийн сүлжээнд оролцох

- 6.1 Мөшгөлтийн гарын авлагыг хүлээн авах
- 6.2 Баталгаажсан үйлдвэртэй бэлтгэн нийлүүлэлтийн гэрээ байгуулж, арилжаа хийх
- 6.3 Борлуулалтын баримт, борлуулалтын гэрчилгээ авах

7

Түншлэл хамтын ажиллагаа, тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх

Бэлтгэн нийлүүлэгч малчдын байгууллага нь ТННЭ-тэй байнгын хамтын ажиллагаатай байна.

ТННЭ-ИЙН ГИШҮҮДИЙН НЭРЭМЖИТ ТУСГАЙ ХӨТӨЛБӨРҮҮД

ТННЭ-ийн гишүүд өөрсдийн нэрэмжит хөтөлбөрийг дэмжин урт хугацааны орон нутгийн тогтвортой хөгжилд шууд хувь нэмрээ оруулсаар байна.

Энэхүү хөтөлбөрүүд нь орон нутгийн хөгжлийг дэмжихийн тулд малчны байгууллага, хоршоотой хамтран шийдвэрлэх зорилготой бөгөөд худалдаа бэлтгэлийн чанарыг баталгаажуулж, өртгийн сүлжээг сайжруулах, бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах зарчимд суурилан хэрэгжүүлдэг онцлогтой.

Гишүүдийн нэрэмжит хөтөлбөрүүд:

Залуу малчдын сургалт “Шинэ зууны малчин”

“Малчны хоршооны удирдлагын” чадамжинд суурилсан сургалт

Мал сүргийн үүлдэр угсааг сайжруулах

- “Бог мал үржүүлэх” чадамжинд суурилсан сургалт
- “Малын эрүүл мэндийг хамгаалах” чадамжинд суурилсан сургалт

Эмэгтэйчүүдийг чадавхижуулах хөтөлбөр

- “Ноолуур Ангилан бэлтгэх” чадамжинд суурилсан сургалт

Бэлчээрийн даац ба байгалийн нөөцийн судалгаа, мониторинг гэж юу вэ, хэнээс мэдээлэл авах вэ, хэрхэн ашиглах вэ?

Зэрлэг амьтдын амьдрах орчинг хэрхэн хамгаалах вэ?

Тогтвортой арга ажиллагааг нэвтрүүлсэн ажил санаачлагын шагнал, урамшуулал





ТОГТВОРТОЙ НООС НООЛУУРЫН ЭВСЭЛ

Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний
тогтвортой байдлыг хөгжүүлэхийн төлөө

БИДЭНТЭЙ ХОЛБОГДОХ:

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Олимпын гудамж, Гранд оффис 23 тоот

Утас: 976-7011 5559
И-мэйл: admin@sustainablefibre.mn
Вэб: www.sustainablefibre.mn